**АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# МӨРӨН ХОТ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2024/18/НА-СТА-ӨНА

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/252
танай ______-ны № ______-т

"МӨРӨН ХОТ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ" ХХК-ИЙН ДАРГА Ц.ЗОРИГТ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн хэсэгт дурьдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна,* 12.2.1 *"жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"* 12.2.2-т *"Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ",* 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын *"тасалбар болголт"*, *"оршин байх"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2. Санхүүгийн байдлын тайланд тусгасан 28.0 сая төгрөгийн авлага, 11.6 сая төгрөгийн өглөгийг холбогдох байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх,*

6724040660

*бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтыг зөрчсөн, "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны 12 тоот тогтоолоор "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ийн өмчлөлийн эрхийг Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1,686.4 сая төгрөгийн алдааг залруулж, анхан шатны бүрдэлтэй холбоотой 8.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагнал, татварын өр авлагатай холбоотой нийт 2,607.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

"Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК нь бизнес төлөвлөгөө хоёр төрлөөр боловсруулан төсвийн төслийг Мөрөн сумын Засаг даргад, бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан ажилласан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж, бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Хөрөнгө** | **-** | **-** |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | **-** | **-** |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 48,065,926.62 | 46,268.07 |
| 1.1.2 | Дансны авлага | 18,414,083.00 | 22,074,083.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 432,335.00 | 5,965,009.56 |
| 1.1.6 | Бараа материал | 99,107,113.82 | 81,221,871.43 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **166,019,458.44** | **109,307,232.06** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 4,970,028,977.83 | 1,925,224,052.45 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 8,751,600.15 | 880,262,808.27 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **4,978,780,577.98** | **2,805,486,860.72** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,144,800,036.42** | **2,914,794,092.78** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 7,310,398.95 | 115,857,287.55 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 751,200.00 | 754,061.36 |
| 2.1.1.3 | Татварын өр | 71,337,382.78 | 108,160,511.00 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 3,174,423.64 | 63,477,413.51 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 15,600.00 | 5,600.00 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **82,589,005.37** | **288,254,873.42** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **82,589,005.37** | **288,254,873.42** |
| **2.3** | **Эздийн өмч** | **6,772,480,793.00** | **6,772,480,793.00** |
| 2.3.1 | төрийн | 6,772,480,793.00 | 6,772,480,793.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 2,492,515,793.17 | 2,492,515,793.17 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 5,445,523,894.02 | 3,685,022,149.20 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг, алдагдал | (9,648,309,449.14) | (10,323,479,516.01) |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **5,062,211,031.05** | **2,626,539,219.96** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **5,144,800,036.42** | **2,914,794,092.78** |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 1,807,262,458.00 | 1,690,055,709.19 |
| 8 | Бусад орлого | | 520,000.00 |
| **3** | **Нийт ашиг ( алдагдал)** | **1,807,262,458.00** | **1,690,575,709.19** |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,041,367,220.87 | 2,357,406,406.59 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (1,544,666.97) | (8,339,369.47) |

| | | | |
|---|---|---|---|
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(235,649,429.84)** | **(675,170,066.87)** |
| **20** | **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **(235,649,429.84)** | **(675,170,066.87)** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **(235,649,429.84)** | **(675,170,066.87)** |
| **24** | **Нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | **(235,649,429.84)** | **(675,170,066.87)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмч Халаасны хувьцаа | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **6,724,807.93** | **2,492,515,793.17** | **4,705,270,529.02** | **(9,412,660,019.30)** | **4,557,607,095.89** |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 6,724,807.93 | 2,492,515,793.17 | 4,705,270,529.02 | (9,412,660,019.30) | 4,557,607,095.89 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | (235,649,429.84) | (235,649,429.84) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 740,253,365.00 | - | 740,253,365.00 |
| **9** | **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **6,724,807.93** | **2,492,515,793.17** | **5,445,523,894.02** | **(9,648,309,44.14)** | **5,062,211,031.05** |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 6,724,807.93 | 2,492,515,793.17 | 5,445,523,894.02 | (9,648,309,44.14) | 5,062,211,031.05 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | (675,170,066.87) | (675,170,066.87) |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | (1,760,501,744.82) | - | (1,760,501,744.82) |
| **17** | **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **6,724,807.93** | **2,492,515,793.17** | **3,685,022,149.20** | **(10,323,479,516.01)** | **2,626,539,219.36** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн** | **1,732,847,284.00** | **1,578,050,557.46** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,732,847,284.00 | 1,578,050,557.46 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,689,508,648.55** | **1,626,070,216.01** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 602,538,215.92 | 732,374,644.33 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 302,759,416.72 | 153,462,465.60 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 88,638,311.00 | 119,369,918.45 |
| 1.2.4 | Ашиглалтын зардал төлсөн | 115,458,456.35 | 89,520,223.35 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 463,817,810.86 | 432,982,327.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 12,198,017.91 | 28,621,851.18 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 3,102,462.00 | 4,755,825.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 100,995,957.79 | 64,982,961.10 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **43,338,635.45** | **(48,019,648.55)** |
| **4.1** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **43,338,635.45** | **(48,019,658.55)** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **4,727,291.17** | **48,065,926.62** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **48,065,926.62** | **46,278.07** |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшний гүйцэтгэл**
**2023 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/**

| дд | Үзүүлэлт | Бизнес төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн төсвийн санхүүжилт | 1,638,201,200.00 | 1,427,258,705.08 | -210,942,494.2 | 87.1 |
| 2 | Автобусны орлого | 29,262,942.00 | 20,651,400.00 | -8,611,542.00 | 70.6 |
| 3 | Нохой устгалын орлого | 10,000,000.00 | 2,500,000.00 | -7,500,000.00 | 25.0 |
| 4 | Хаяг рекламны самбарын орлого | 5,680,000.00 | 4,680,000.00 | -1,000,000.00 | 82.4 |
| 5 | Гудамжны гэрэлтүүлгийн засварын орлого | 621,600.00 | 295,000.00 | -326,600.00 | 47.5 |
| 6 | Машин механизм түрээсийн орлого | | 7,258,000.00 | 7,258,000.00 | |
| 7 | Ногоон байгууламжийн орлого | 44,474,218.00 | 10,745,000.00 | -33,729,218.00 | 24.2 |
| 8 | Бусад орлого | 56,317,300.00 | 174,633,314.11 | 124,629,014.11 | 321.3 |
| 9 | Тоглоомын орлого | 47,000,000.00 | 39,254,290.00 | -7,74,.710.00 | 83.5 |
| 10 | Чулууны үйлдвэрийн орлого | | 1,040,000.00 | 1,040,000.00 | |
| 11 | Талбайн түрээс | 3,912,000.00 | 2,260,000.00 | -1,652,000.00 | 57.8 |
| 12 | **Нийт орлогын дүн** | **1,835,469,260.00** | **1,690,575,709.19** | **-138,580,550.81** | **92.4** |
| 14 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 880,915,910.00 | 824,021,500.75 | -56,894,410 | 93.5 |
| 15 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,328,227 | 117,769,754.82 | -5,558,472.18 | 95.5 |
| 16 | Гэрэл цахилгааны зардал | 15,360,042.00 | 20,818,179.69 | 5,458,13769 | 135.5 |
| 17 | Бичиг хэргийн зардал | 2,939,500.00 | 5,338,230.97 | 2,398,730.97 | 181.6 |
| 18 | Шуудан холбооны зардал | 1,901,994.00 | 2,680,970.33 | 778,976.33 | 140.9 |
| 19 | Мэргэжлийн үйлчилгээний зардал | | 27,247,100.00 | 27,247,100.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | Сургалтын зардал | | 1,810,000.00 | 1,810,000.00 | |
| 21 | Даатгалын зардал | 2,504,190.00 | 5,599,075.00 | 3,094,885.00 | 223.6 |
| 22 | Түлш халаалт зардал | 15,730,616.00 | 15,730,662.00 | 46.00 | 100,00 |
| 23 | Хөдөлмөр хамгаалал | 17,452,480.00 | 24,375,705.79 | 6,923,225.79 | 139.7 |
| 24 | Элэгдэл, хорогдлын зардал | - | 441,101,022.97 | 441,101,022.97 | - |
| 25 | Тээврийн зардал | - | 2,048,000.00 | 2,048,000.00 | - |
| 26 | Тээвэр шатахууны зардал | 652,037,486.00 | 381,211,579.54 | -280,745,900.46 | 57.6 |
| 28 | Сэлбэгийн зардал | 120,614,500.00 | 119,105,305.69 | -1,509,194.31 | 98.7 |
| 29 | Бусад хангамжийн материалын зардал | 84,602,000.00 | 188,580,771.00 | 103,978,771.00 | 222.9 |
| 30 | Албан татвар төлбөр хураамжийн зардал | 1,534,425.00 | 413,900.00 | -1,120,525.00 | 27.0 |
| 31 | Банкны шимтгэлийн зардал | | 217.400,00 | 217.400,00 | |
| 32 | Бусад зардал | - | 12,515,963.92 | -58,725,248.81 | 17.6 |
| 34 | Албан татварын төлбөр хураамжийн зардал | 1,511,000.00 | 7,173,333.96 | 5,662,333.96 | 474.7 |
| 35 | Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | | 200,000.00 | 200,000.00 | |
| 36 | Санхүүгийн программын зардал | | 1,252,900.00 | 1,252,900.00 | |
| 37 | Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн зардал | 87,014,000.00 | 103,768,280.28 | 16,754,280.28 | 119.2 |
| 38 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал | 24,800,000.,00 | 54,973,789.88 | 30,173,789.88 | 221.7 |
| **39** | **нийт зардлын дүн** | **1,835,469,260.00** | **2,357,953,406.59** | **522,484,146.59** | **128.5** |
| **42** | **нийт ашиг, алдагдал** | **(235,649,429,84)** | **(675,170,066.87)** | **439,520,637.03** | **286.51** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,610.6 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 4 албан шаардлага, алдааг дахин гаргахгүй байх талаар 7 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

### 3.1 Залруулга

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 тоот тогтоолоор нийт 1,686.0 сая төгрөгийг хөрөнгийг үндсэн хөрөнгийг /51.4 сая төгрөгийн өртөгтэй Эргийн-72 уурын зуухны 2058 м2 газар, 50.2 сая төгрөгийн өртөгтэй үйлдвэрийн газар хоймор нутгийн чулууны 1942 м2 газар, 1.6 сая төгрөгийн өртөгтэй Хүүхдийн паркын 63,392.8 м2 газрыг/ данснаас хасахаар шийдвэрлэсэнийг үндсэн хөрөнгийн элэгдэл дансанд буруу бүртгэснийг залруулсан.

### 3.2 Албан шаардлага

**1. Илрүүлэлт:**

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 8.4 сая төгрөгийн НӨАТ-ийн цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг

бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.1-д “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага

**2. Илрүүлэлт:**

Тайлант оны эцэст 28.0 сая төгрөгийн авлага, 11.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага

**3. Илрүүлэлт:**

2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байгаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна: ... 12.2.2-т "Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ", 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “тасалбар болголт”, “оршин байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага

**4. Илрүүлэлт:**

Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын 222,9 сая төгрөгийн 15 мэдээллийг мэдээлээгүй,таван сая төгрөгнөөс дээш худалтан авалтын 46,6 сая төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай, мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

**<u>1. Илрүүлэлт</u>**

Авто тээврийн үндэсний төвөөс бүртгэлтэй тээврийн хэрэгслийн судалгаа авахад гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний өргөгчтэй машин 1, Ковш 30 машин 1 бүгд 2 машин улсын бүртгэлд бүртгэлгүй, Зил ММЯ554М машин 1, Daewoo BM-090 машин 1, Foton BT5052 машин 1, нийт 3 машин улсын бүртгэлд бүртгэлтэй санхүүгийн тайланд бүртгэлгүй байгаа нь Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 14.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана, 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дараалаар гүйцэтгэнэ", 14.3.2.журналд бичих, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх " гэж заасантай нийцэхгүй, "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>:**

Дээрхи авто тээврийн хэрэгслэлүүдийн баримт бичгийн зөрчлийг арилгаж, үндсэн хөрөнгийн анхан шатны баримтыг бүрдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

**<u>2. Илрүүлэлт</u>:**

Татварын тодорхойлолтоор 2,180.0 сая төгрөгийн илүү, 95.3 сая төгрөгийн дутуу төлөлттэй байгаа боловч санхүүгийн байдлын тайлан дахь татварын авлага дансанд үлдэгдэлгүй байгаа, нийгмийн даатгалын тайлангаарх 835.8 сая төгрөгийн цалингийн зардлыг ерөнхий журнаалаарх дүнтэй тулган шалгахад 69.6 сая төгрөг, ХХОАТ-ын тайлангийн дүнтэй тулган шалгахад 11.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хянах тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасантай нийцэхгүй, "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>**:

Татвар, Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж актаар баталгаажуулан зөрчлийг арилгаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

**<u>3. Илрүүлэлт:</u>**

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 76 нэр төрлийн (анхны өртөг 577.6 сая төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1."Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 76 нэр төрлийн (анхны өртөг 577.6 сая төгрөг) хөрөнгийг дахин үнэлүүлж данс бүртгэлд тусгаж, Төрийн болон орон нутгийн тухай хууль, холбогдох журмуудыг хэрэгжүүлж ажиллах;

**<u>4. Илрүүлэлт</u>:**

Тайлант онд сургалтын төлбөрийн 1.8 сая төгрөгийг холбогдох тушаал шийдвэргүйгээр гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв

гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>:**

Алдааг давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

**<u>5. Илрүүлэлт</u>:**

Төлбөртэй үйлчилгээний орлогыг ажлын дараа өдөрт тушааж хэвшээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана.” гэсэн заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>**: Алдааг давтан гаргахгүй байх,Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлж ажиллах

**<u>6. Илрүүлэлт</u>:**

Нийгмийн даатгалын тайлангаарх 835.8 сая төгрөгийн цалингийн зардлыг ерөнхий журналаарх дүнтэй тулган шалгахад 69.6 сая төгрөг, ХХОАТ-ын тайлангийн дүнтэй тулган шалгахад 118 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.7-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хянах тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" заалттай нийцээгүй гэсэн заалт заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>**: Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй ажиллах

**<u>7. Илрүүлэлт</u>:**

Орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт 1,696.9 сая төгрөгийн борлуулалтын орлогыг цахим и-баримтаарх борлуулалтын дүнтэй тулган шалгахад 148.4 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь хяналт хийдэггүй, харилцагч байгууллага болон хувь хүмүүст орлогын баримтыг бүрэн шивж өгдөггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтад “Харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийхээс гадна төрийн эрх бүхий байгууллага нь энэхүү цахим санд баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг ашиглана” заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж</u>**: Харилцагч байгууллага болон хувь хүмүүст орлогын баримтыг бүрэн шивж өгч байх, давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган | Үнээс | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|

| | | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | илэрхийлсэн | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 тоот тогтоолоор нийт 1,686,415.0 мянган төгрөгийг хөрөнгийг үндсэн хөрөнгийг данснаас хасахаар шийдвэрлэсэний г үндсэн хөрөнгийн элэгдэл дансанд буруу бүртгэсэн байна. | 1 | 1,686,415.0 | | | 1 | 1,686,415.0 | 1 | 1,686,415.0 | | | | |
| **Дүн** | **1** | **1,686,415.0** | | | **1** | **1,686,415.0** | **1** | **1,686,415.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Авто тээврийн үндэсний төвөөс бүртгэлтэй тээврийн хэрэгслийн судалгаа авахад гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний өргөгчтэй машин 1, Ковш 30 машин 1 бүгд 2 машин улсын бүртгэлд бүртгэлгүй, Зил ММЯ554М машин 1, Daewoo BM-090 машин 1, Foton BT5052 машин 1, нийт 3 машин улсын бүртгэлд бүртгэлтэй санхүүгийн тайланд бүртгэлгүй байна. | 1 | 99,583.3 | | | | | 1 | 99,583.3 | | | | |
| Татварын тодорхойлолтоор | 1 | 2,275,362.3 | | | | | 1 | 2,275,362.3 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2,180,026.8 мянган төгрөгийн илүү, 95,335.5 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байгаа боловч санхүүгийн байдлын тайлан дахь татварын авлага дансанд үлдэгдэлгүй байна. | | | | | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 76 нэр төрлийн (анхны өртөг 577,653.1 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 8,415.0 мянган төгрөгийн НӨАТ-ийн цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй байна. | 1 | 8,415.0 | | | 1 | 8,415.0 | | | | | | |
| Нийгмийн даатгалын тайлангаарх 835,806.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг ерөнхий журналаарх дүнтэй тулган шалгахад 69,605.3 мянган төгрөг, ХХОАТ-ын тайлангийн дүнтэй тулган шалгахад 11,785.3 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 81,390.5 | | | | | 1 | 81,390.5 | | | | |
| Тайлант оны эцэст 28,039.1 мянган төгрөгийн авлага, 11,620.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 39,659.1 | | | 1 | 39,659.1 | | | | | | |
| Тайлант онд сургалтын төлбөрийн 1,810.0 мянган төгрөгийг | 1 | 1,810.0 | | | | | 1 | 1,810.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| холбогдох тушаал шийдвэргүйгээр гаргасан байна. | | | | | | | | | | | | |
| Төлбөртэй үйлчилгээний орлогыг ажлын дараа өдөрт тушааж хэвшээгүй байна | 1 | | | | | | 1 | | | | | |
| 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. | 1 | | | | 1 | | | | | | | |
| Орлогын дэлгэрэнгүй тайлангаарх нийт 1,696,888.7 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг цахим и-баримтаарх борлуулалтын дүнтэй тулган шалгахад 148,445.8 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь хяналт хийдэггүй, харилцагч байгууллага болон хувь хүмүүст орлогын баримтыг бүрэн шивж өгдөггүй байна. | 1 | 148,445.8 | | | | | 1 | 148,445.8 | | | | |
| **Дүн** | **10** | **2,654,666.0** | | | **3** | **48,074.1** | **7** | **2,606,591.9** | | | | |

### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын 222,896.7 мянган төгрөгийн 15 мэдээллийг мэдээлээгүй,таван сая төгрөгнөөс дээш худалтан авалтын 46,608.3 мянган төгрөгийн 5 мэдээллийг | 1 | 269,505.0 | | | 1 | 269,505.0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| мэдээлээгүй байна. | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **269,505.0** | | | **1** | **269,505.0** | | |

## 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| **НИЙТ** | | **1** | | | | **1** | | | |